

УРИАЛГА

Үйлдвэр, хөдөө аж ахуйн салбар Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 40-өөд хувийг үйлдвэрлэдэг Монгол Улсын том салбар билээ. Салбарын нийт хамт олондоо хандан Улс орны ирээдүйн хөгжил дэвшилд нэн хамааралтай нэгэн чухал асуудал болох авлигатай тэмцэж “Авилгаас ангид салбар” болох энэхүү Уриалгыг гаргаж байна.

Нэг. Салбарын бүх шатны Төрийн байгууллагын албан хаагчдад хандан Уриалах нь:

1.1 Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоогдсон төрийн үйл ажиллагааны Шударга ёсны үндсэн зарчим, Ардчилсан ёсны үндсэн зарчим, Хууль дээдлэх үндсэн зарчим болон Төрийн албаны тухай хуулиар тогтоосон Төрийн албаны ард түмэндээ үйлчлэх зарчмыг бүх төрийн албан хаагчид өдөр тутмын үйл ажиллагаандаа удирдлага болгон эх орон, ард түмнийхээ сонирхлыг хувийн ашиг сонирхлоос ямагт дээгүүр тавьж өөрт олгогдсон албан тушаалын бүрэн эрхээ шударгаар хэрэгжүүлэх,

1.2 Төрийн албан хаагчийн хувьд өөрийн албан тушаалын давуутай тал боломжийг хувийн зорилгоор ашиглах, аль нэг этгээдийн өмнө ямар нэг үүрэг хүлээх байдалд түүнийг оруулж болзошгүй бэлэг, шагнал урамшуулал авах, албаны нэр барих зэргээр албан тушаал эрх мэдлээ ашиглах зэрэг ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чандлан сахиж өргөсөн тангарагтаа үнэнч байх,

1.3 Төрийн аливаа үйлчилгээг хүргэхдээ хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, үзэл бодлоор нь ялгаварлахгүйгээр тэгш шударга хандан иргэд, үйлчлүүлэгч хамтран ажилладаг байгууллагуудтайгаа хүндэтгэлтэй харьцаж тэдний илтгэл, хүндэтгэлийг хүлээх

Хоёр. Салбарын Хувийн хэвшлийн байгууллагуудад хандан Уриалах нь:

2.1 Монгол Улсын эдийн засагт салбарын хувийн хэвшлийнхний гүйцэтгэх үүрэг өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж байгаа хэдий ч түүний хөгжилд олон саад бэрхшээлүүд тулгарч байгаагийн нэг нь авлига хүнд суртал болж байгаа билээ. Улс орны эдийн засгийн хөгжил, бизнесийн өсөлт хөгжил, ард түмний сайн сайхан байдалд сөргөөр нөлөөлж байгаа энэхүү хүчин зүйлийг арилгахад Төрийн байгууллага болон бизнесийн байгууллагууд хуулийн хүрээнд хамтран ажиллаж, харилцан бие биенээ хүндэтгэж бизнесийн ёс зүйтэй байж зөвхөн өөрийн ашгийн төлөө бус нийтийн, нийгмийн эрх ашгийн төлөө хүчин чармайлт гаргаж ажиллах,

2.2 Төрийн байгууллагад хандаж шийдвэр гаргуулахдаа хууль, журмын дагуу асуудлаа тавьж хуулийн дагуу хариугаа авдаг байх,

2.3 Төрийн албан хаагчийн ёс зүйг зөрчиж санаатай хүндрэл, чирэгдэл учруулж байгаа Төрийн албан хаагчийн талаар нээлттэй мэдээлж авлига, хээл хахуулийг дор бүр нь таслан зогсоож, авлигын эсрэг бүх талаар хамтран ажиллах, “Авилгаас ангид салбар” Энэхүү Уриалгыг хэрэгжүүлж сайн үйлсийн төлөө хамран ажиллацгаая.